

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАДААД АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 09

Улаанбаатар

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ					
Байгууллагын нэр	Мэргэжилтний нэр /тайлан бичсэн/	Албан тушаал	Холбоо барих утас	Цахим майл хаяг	Он сар өдөр
Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	Б.Сайнбаяр	Захиргааны хэлтсийн мэргэжилтэн	330423 99020791	Sainbayar.b@hhaag.ub.gov.mn	2016.12.05
НЭГ. ГАДААД ТОМИЛОЛТ					
	Захирамж шийдвэрийн хугацаа	Хамрагдсан хугацаа	Улс, хот	Зорилго, үр дүн	Зардлын эх үүсвэр
“Хөдөө аж ахуйн нарийн мэргэжлийн, үйлдвэрлэл, үйлчилгээ” сэдэвт сургалт	-	2016 оны 02-р сарын 14-25 өдрүүдэд	Энэтхэг улсын Шинэ Дели, хот	Энэтхэг улсын жимс жимсгэнэ, хүнсний ногоо, самар самран бүтээгдэхүүний салбарын арга туршлагыг хөгжиж буй орнуудад нэвтрүүлэхэд ихээхэн үр дүнгээ өгсөн сургалт болж чадсан ба тус улсын худалдаа, тээвэрлэлтийн асуудлыг цогцоор шийдэхэд түлхэц болж өгсөн Олон улсын Дэлхийн худалдааны байгууллага (WTO) – ын ач холбогдол үр өгөөжийн талаар таниулахад ихээхэн үр дүнгээ өгсөн сургалт боллоо. Монгол улс нь Дэлхийн худалдааны байгууллагад (WTO)-д 2010 оноос гиншүүлчлэлээр элссэн. Тус сургалтаар сурсан мэдлэгээ өөрийн орны байгаль цаг уурын онцлогт тохируулан нэвтрүүлж ажиллах, хүнсний ногооны тариалалтын орчин үеийн шинэлэг технологийг тариалан эрхлэгчдэдээ дамжуулах мэдлэг чадварыг нь дээшлүүлэхэд анхаарч ажиллах, цаашдаа энэтхэг улсын тариаланч	Энэтхэг улсын Хөдөө аж ахуйн яамны харъяа Гадаад худалдааны институт

				фермерүүдтэй холбоо тогтоож туршлага солилцоход дэмжлэг болон хамтран ажиллах бололцоог судлан ажиллаж байна.	
Зүүн Өмнөд Ази дахь Сэргээгдэх эрчим хүчний зах зээлийн өсөлтийг хурдасгах, “Хог хаягдлаас эрчим хүч гаргах” сэдэвт сургалт, форум	-	2016 оны 6-р сарын 7- оос 9 -ны өдрүүдэд	Филиппин улсын Манила хот	Нар, салхи, ус, мод гэх мэт сэргээгдэх эрчим хүчийг хэрхэн зөв зохистой ашиглаж байгаа талаар гадаад орнуудын туршлагатай танилцаж, Монгол улсад нэвтрүүлэх талаар компани төлөөлөгчтэй санал солилцлоо. Мөн Хог хаягдлын менежментийг хэрхэн сайжруулах, төрөл бүрийн хогноос хэрхэн эрчим хүч боловсруулж байгаа туршлагатай танилцаж Франц, Филиппин, Герман, Испан зэрэг орнуудийн төлөөлөгчидтэй уулзаж, санал солилцсон.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр
“Жимс, хүнсний ногооны аюулгүй байдал” сэдэвт сургалт	-	2016 оны 04-р сарын 14-27 өдрүүдэд	Тайвань улсын Тайпей, Тайжун хот	Тайвань улсын жимс, хүнсний ногооны салбарын арга туршлагыг хөгжиж буй орнуудад нэвтрүүлэхэд ихээхэн үр дүнгээ өгсөн сургалт болж чадсан ба тус улсын сүүлийн үеийн техник технологийн дэвшилтэт аргыг газар дээр нь үзэж танилцсанаараа онцлогтой сургалтад оролцогчдод үр дүнгээ өгсөн сургалт боллоо. Тус сургалтаар сурсан мэдлэгээ өөрийн орны байгаль цаг уурын онцлогт тохируулан нэвтрүүлж ажиллах, хүнсний ногооны тариалалтын хугацаанд химийн болон органик бордооны зөв зохистой хэрэглээг газар тариалан эрхлэгчдэд дамжуулах, Тайвань улсын фермерүүдийн нэгдсэн бүртгэлжүүлэлтийн арга туршлагыг эх орондоо нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх, газар тариалан эрхлэгчдийн бага оврын тоног төхөөрөмж худалдан авах боломжийг судлах, иргэдэд мэдээлэл хүргэх замаар худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх, тус	Тайваны хамтын ажиллагааны хөгжлийн сангийн санхүүжилт

				улсын фермерүүдийн холбоодуудтай холбоо тогтоож туршлага судлуулах, мэргэжилтэн урьж ажиллуулах замаар үнэтэй зөвлөгөө авах, талаар хамтран ажиллах хүсэлтээ Тайваны хамтын ажиллагааны санд гаргасан ба албан ёсоор хүсэлт тавихаар саналаа боловсруулж байна.	
“Мал аж ахуйн мэргэжилтэнүүдэд зориулсан” сэдэвт сургалт	-	2016 оны 05-р сарын 15-6 дугаар сарын 05 өдрүүдэд	Хятад улсын чангчун хот	Хятад улсын мал аж ахуйн салбарын арга туршлагыг хөгжиж буй орнуудад нэвтрүүлэхэд ихээхэн үр дүнгээ өгсөн сургалт болж чадсан ба тус улсын сүүлийн үеийн техник технологийн дэвшилтэт аргыг газар дээр нь үзэж танилцснаараа онцлогтой сургалтанд оролцогчдод үр дүнгээ өгсөн сургалт боллоо. Тус сургалтаар сурсан мэдлэгээ өөрийн орны байгаль цаг уурын онцлогт тохируулан нэвтрүүлж ажиллах, мал аж ахуйн бүтээгдэхүүний өсөлт үнийн тогтвортой байдлыг хэрхэн ханган үйлдвэрлэлийг эрчимжүүлэх фермер эрхлэгчдэд дамжуулах, Хятад улсын фермерүүдийн нэгдсэн бүртгэлжүүлэлтийн арга туршлагыг эх орондоо нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх, газар тариалан эрхлэгчдийн бага оврын тоног төхөөрөмж худалдан авах боломжийг судлах, иргэдэд мэдээлэл хүргэх замаар худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх, тус улсын фермерүүдийн холбоодуудтай холбоо тогтоож туршлага судлуулах, мэргэжилтэн урьж ажиллуулах замаар үнэтэй зөвлөгөө авах, нэвтрүүлэх хүсэлтээ хятад улсын чангчун хотын хөдөө аж ахуйн их сургуулийн гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэнд тавьсан. Төв аймгийн Хөдөө	Монгол улсын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам

				аж ахуйн газар, Чангчунын хөдөө аж ахуйн сургуультай хамтрын ажиллагаатай бөгөөд жил бүр монгол оюутан сургуульдаа элсүүлэн авдаг.	
“Азийн орнуудын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний, худалдаа, түгээлт” сэдэвт сургалт	-	2016 оны 05 дугаар сарын 17 - 6 дугаар сарын 08	БНХятад ард улс, Бээжин хот, Ляонин муж Шенян хот Жансу, муж Лянюаньган хот	Сургалтад 6 орны нийт 23 төлөөлөгч оролцлоо. Сургалтын хугацаанд Бээжин хот, Ляонин мужийн Шенян хот, Жансу мужийн Лянюаньган хотуудаар тус тус явж Хятад улсын хөдөө аж ахуйн өнөөгийн байдал, дэвшилтэт шинэ технологийг өөрийн хөдөө аж ахуйн салбарт хэрхэн ашиглаж өндөр үр дүнд хүрч байгааг газар дээр нь үзэж танилцсан. Худалдаа, түгээлтийн том хотууд болох Шенян, Лянюаньган хотуудад ажиллаж борлуулалтын томоохон цэг болон түгээлтийн боомт хотуудтай танилцаж Хятад улсын хөдөө аж ахуйн шуурхай мэдээллийн төв дээр ажилласан. Мөн хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдыг хэрхэн төр засгаас санхүү эдийн засгийн дэмжлэг үзүүлэн цаашид тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэх, тэдэнд хөнгөлөлттэй нөхцлөөр хамгийн сүүлийн үеийн хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмжийг олгодог зэрэг Хятад улсын өнөөгийн амжилтанд хүрсэн онолын хичээлүүдээс их зүйл сурч сонсож ирсэн. Мөн Нийслэл хотод хүлэмжийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд аж ахуйн нэгжүүдийн дунд хүнсний ногооны сургалт зохион байгуулахдаа тус улсад суралцаж мэдсэн туршлагыг хуваалцаж мэдээлэл солилцон ажиллахаар болсон.	Монгол улсын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам
Газар тариалангийн чиглэлээр сургалтанд хамрагдах, туршлага	-	2016 оны 10 дугаар сарын 31-нээс 11	Энэтхэг Улс	Тус сургалтад 13 орны 16 төлөөлөгч оролцсон ба Монгол улсаас ганцаараа оролцлоо.	Бүгд найрамдах Энэтхэг улсын

судлах		дүгээр сарын 27-ны өдрүүдэд		<p>Сургалтад оролцогч бүр өөр өөрийн орны талаар товч мэдээлэл, газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийсэн ба сургалтын хугацаанд нийт оролцогчид 2 бүлэгт хуваагдан тайлан бэлтгэж, хаалтын ажиллагааны үеэр танилцууллаа.</p> <p>Энэхүү сургалт нь Энэтхэг улсын хөдөө аж ахуйн салбарын арга туршлага, орон нутгын ядуурлыг бууруулахад төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, алдаа оноо, туршлагыг хөгжиж буй орнуудад нэвтрүүлэх, дамжуулахад үр дүнгээ өгсөн сургалт боллоо.</p> <p>Тус улс нь ядуурлын түвшингээрээ дэлхийд тэргүүлдэг ба хүн амын 41,01% нь ядуу, үүнээс 28,2% нь нэн ядуу тул орон нутгын онцлогоосоо хамаарч ядуурлыг бууруулахад хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх бодлого баримтладаг юм байна.</p> <p>Сургалтаас Энэтхэгийн Засгын газраас хөдөө аж ахуйн салбарт баримталж буй бодлого, дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулахдаа анхаарах асуудлуудын талаар суралцаж мэдлэгээ өргөжүүллээ. Цаашид сурсан мэдлэгээ өөрийн орны байгаль цаг уурын онцлогт тохируулан нэвтрүүлж цаашдын ажилдаа хэрэгжүүлэн ажиллах болно. Мөн тус сургалтыг зохион байгуулсан орон нутгын хөгжлийн үндэсний төвийн удирдлагуудад Монголын газар тариалан эрхлэгчдийн бүртгэлжүүлэлт хийхэд Энэтхэгийн талаас мэргэжил арга зүй, хөрөнгө санхүүжилтийн дэмжлэг авах,</p>	Засгийн газрын тэтгэлэг
--------	--	-----------------------------------	--	---	----------------------------

				<p>органик газар тариалан эрхлэхэд зөвлөгөө мэдээлэл авч байх, хөдөө аж ахуйн чиглэлээр зохион байгуулагдаж буй сургалтуудад мэргэжилтнүүдээ хамруулах зэрэг хүсэлтүүдийг тавьсан болно.</p> <p>Тус байгууллагын зүгээс цаашид зохион байгуулагдах сургалтуудад төрийн байгууллагын мэргэжилтнүүдийг хамруулах боломжтой, мэдээллийг дамжуулж байх, харин бүртгэлжүүлэлтийг программ хийх төслийг Монгол улсад суугаа Энэтхэгийг элчин сайдад албан ёсоор бичиж өгвөл хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэсэн хариу өгсөн.</p>	
ХОЁР. ГЭРЭЭ, САНАМЖ БИЧИГ					
	Гэрээ, санамж бичиг байгуулсан албан тушаалтан	Он сар өдөр	Улс, хот	Зорилго	Биелэлт, үр дүн
-	-	-	-	-	-
ГУРАВ. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА					
	Шийдвэрийн хугацаа	Он сар өдөр	Улс, хот	Зорилго	Биелэлт, үр дүн
Харилцаат дүүрэг, хотуудтай хэрэгжүүлсэн уламжлалт арга хэмжээ	-	-	-	-	-
Гадны зочдыг хүлээн авсан	-	-	-	-	-
Бусад арга хэмжээ	-	-	-	-	-